



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/15/НА-СТА-ОНӨ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Болдбаатар Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
5.1 Төлбөрийн акт .....	11
5.2 Албан шаардлага .....	12
5.3 Зөвлөмж.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН  
ЭРДЭНЭЦАГААН СУМЫН  
ЧОНОГОЛ ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ө.БАТСАЙХАН ТАНАА

2023.03.22 № 161  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Чоногол Хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Чоногол Хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр нийтийн эзэмшлийн зам талбайн засвар үйлчилгээ 5.0 сая, зам арчилгааны багаж хэрэгсэл худалдан авах 5.0 сая, нийтийн эзэмшлийн талбайн ажлыг тохижуулах 10.0 сая, нийт 20.0 сая төгрөгийн ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Уурын зууханд цахилгааны хэлбэлзлээс шалтгаалан доголдол гарч түүний хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн засварлахад нийт 19,972.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шинээр суурилуулж, нөөцөөр бэлтгэсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Эрдэнэцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Чоногол -Хөгжил” ОНӨААТҮГ-ийн 2022 оны орлого, зардал, орон тоо цалингийн санг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,973,777.17</b>	<b>42,245,188.09</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,749,674.10</b>	<b>8,683,962.80</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,749,674.10</b>	<b>8,683,962.80</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>6,749,674.10</b>	<b>8,683,962.80</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	6,749,674.10	8,683,962.80
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>21,065,677.07</b>	<b>7,632,015.29</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>21,065,677.07</b>	<b>7,632,015.29</b>
33510	Байгууллагаас авах авлага	21,065,677.07	7,632,015.29
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,158,426.00</b>	<b>25,929,210.00</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,900,000.00	6,300,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,258,426.00</b>	<b>19,629,210.00</b>
35410	Бичиг хэргийн материал	32,000.00	71,000.00
35420	Аж ахуйн материал	1,611,498.00	3,661,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,498,100.00	15,721,000.00
35440	Түлш, шатах тослох материал	116,828.00	176,210.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,389,056.43</b>	<b>66,546,513.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>71,389,056.43</b>	<b>66,546,513.95</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>70,399,056.43</b>	<b>65,556,513.95</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,475,874.46	65,475,874.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,182,529.15	-4,365,058.30
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,420,000.00	8,420,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,601,749.99	-4,453,749.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,424,040.00	2,424,040.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,136,578.89	-1,944,592.22
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>990,000.00</b>	<b>990,000.00</b>
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>109,362,833.60</b>	<b>108,791,702.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>71,953,240.02</b>	<b>74,858,463.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>71,953,240.02</b>	<b>74,858,463.60</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>8,659,894.71</b>	<b>13,747,647.44</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>8,659,894.71</b>	<b>13,747,647.44</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	7,487,963.00	8,747,963.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	1,171,931.71	4,999,684.44
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>63,293,345.31</b>	<b>61,110,816.16</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	63,293,345.31	61,110,816.16
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,409,593.58</b>	<b>33,933,238.44</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>37,409,593.58</b>	<b>33,933,238.44</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>37,409,593.58</b>	<b>33,933,238.44</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	51,403,633.77	37,409,593.58
51220	Тайлант үеийн үр дүн	-13,994,040.19	-3,476,355.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>109,362,833.60</b>	<b>108,791,702.04</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>251,094,335.56</b>	<b>326,831,803.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>251,094,335.56</b>	<b>324,831,803.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>251,094,335.56</b>	<b>304,831,803.89</b>
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	251,094,335.56	304,831,803.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0</b>	<b>22,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	2,000,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0	20,000,000.00

<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>265,088,375.75</b>	<b>330,308,159.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>265,088,375.75</b>	<b>330,308,159.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>265,088,375.75</b>	<b>330,308,159.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>101,500,549.00</b>	<b>112,128,517.63</b>
210101	Үндсэн цалин	88,907,411.00	86,615,525.40
210102	Нэмэгдэл	11,535,820.00	22,795,163.23
210104	Урамшуулал	1,057,318.00	2,717,829.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,557,327.65</b>	<b>15,066,064.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,407,796.77	9,736,572.42
210202	Тэтгэмжийн даатгал	990,294.40	1,024,902.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,980,588.80	2,049,804.73
210204	Ажилгүйдлийн даатгал	198,058.88	204,980.47
210205	Эрүүл мэндийн даатгал	1,980,588.80	2,049,804.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,820,351.00</b>	<b>72,036,669.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,706,351.00	26,161,669.81
210302	Түлш, халаалт	31,700,000.00	45,875,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,414,000.00	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,961,709.67</b>	<b>48,008,984.00</b>
210401	Бичиг хэрэг	274,800.00	323,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,673,893.00	30,884,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	672,000.00	377,762.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,341,016.67	16,423,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,075,600.00</b>	<b>1,352,570.00</b>
210502	Хоол, хүнс	125,600.00	361,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,950,000.00	991,070.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,992,080.00</b>	<b>43,826,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,012,080.00	39,486,700.00
210602	Тавилга	980,000.00	0
210604	Урсгал засвар	0	4,340,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>946,000.00</b>	<b>1,934,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	946,000.00	1,934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,614,467.32</b>	<b>31,112,110.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,125,000.00	1,960,062.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	1,568,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	73,500.00	76,950.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	1,375,200.00	2,567,758.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	4,200,000.00	5,700,000.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	890,000.00	1,375,397.84
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	31,950,767.32	17,863,942.56
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,620,291.11</b>	<b>4,842,542.48</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,620,291.11	4,842,542.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-13,994,040.19</b>	<b>-3,476,355.14</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-13,994,040.19</b>	<b>-3,476,355.14</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,403,633.77	51,403,633.77
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51,403,633.77	51,403,633.77
3	Тайлант үеийн үр дүн	-13,994,040.19	-13,994,040.19
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,409,593.58	37,409,593.58
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,409,593.58	37,409,593.58
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,409,593.58	37,409,593.58
7	Тайлант үеийн үр дүн	-3,476,355.14	-3,476,355.14
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,933,238.44	33,933,238.44

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>251,094,335.56</b>	<b>326,831,803.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>251,094,335.56</b>	<b>324,831,803.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>251,094,335.56</b>	<b>304,831,803.89</b>
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	251,094,335.56	304,831,803.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0</b>	<b>22,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	2,000,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0	20,000,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>271,874,479.07</b>	<b>324,897,515.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>271,874,479.07</b>	<b>324,897,515.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>271,874,479.07</b>	<b>324,897,515.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>101,500,549.00</b>	<b>112,128,517.63</b>
210101	Үндсэн цалин	88,907,411.00	86,615,525.40
210102	Нэмэгдэл	11,535,820.00	22,795,163.23
210104	Урамшуулал	1,057,318.00	2,717,829.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,557,327.65</b>	<b>15,066,064.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,407,796.77	9,736,572.42
210202	Тэтгэмжийн даатгал	990,294.40	1,024,902.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,980,588.80	2,049,804.73
210204	Ажилгүйдлийн даатгал	198,058.88	204,980.47
210205	Эрүүл мэндийн даатгал	1,980,588.80	2,049,804.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,820,351.00</b>	<b>72,036,669.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,706,351.00	26,161,669.81
210302	Түлш, халаалт	31,700,000.00	45,875,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,414,000.00	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>48,643,789.67</b>	<b>92,635,684.00</b>
210401	Бичиг хэрэг	274,800.00	323,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,673,893.00	36,024,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	672,000.00	377,762.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	18,682,080.00	39,486,700.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	7,341,016.67	16,423,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,075,600.00</b>	<b>1,352,570.00</b>
210502	Хоол, хүнс	125,600.00	361,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,950,000.00	991,070.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,510,000.00</b>	<b>4,340,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,530,000.00	0
210602	Тавилга	980,000.00	0
210604	Урсгал засвар	0	4,340,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>946,000.00</b>	<b>1,934,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	946,000.00	1,934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,820,861.75</b>	<b>25,404,009.04</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,200.00	4,527,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	1,568,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	73,500.00	76,950.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	41,357,161.75	17,863,942.56
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	890,000.00	1,367,296.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-20,780,143.51</b>	<b>1,934,288.70</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-20,780,143.51</b>	<b>1,934,288.70</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,529,817.61	6,749,674.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,749,674.10	8,683,962.80

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн зорилго нь “Эрдэнэцагаан сумын нийт төсөвт байгууллага, ААН-ийг дулааны эрчим хүчээр найдвартай хангаж, өөрийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, цаашид тогтвортой ажиллах нөөц бололцоог бүрдүүлэхэд чиглэнэ” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хот тохижилт, ногоон байгууламжийг арчлах, хамгаалах, нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэлт, зам талбайн цэвэрлэгээг хариуцан ажиллах статустай байна.

#### **3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ статустайгаар орон нутгийн өмчийн 100 хувийн өмчлөлтэй, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, автозам, гүүр шинэчлэлт хийх.
- Дээрх нийтийн үйлчилгээний чиглэлээр болоод гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хамгаалах хэтийн төлөвийг тодорхойлох
- Их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ашиглалтад хяналт тавих,.
- Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх,.
- Нийтийн үйлчилгээг бүхэлд нь үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн үйлдвэрийн автомашин механизм, техник хэрэгсэл тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах
- Хайрга, хөрс үйлдвэрлэл, мод үржүүлгийг хөгжүүлэх замаар сумын нийтийн үйлчилгээг хөгжүүлэхэд оршино гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 571.1 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,749.7	8,684.0	1,934.3
Авлага	21,065.7	7,632.0	-13,433.7
Бараа материал	10,158.4	25,929.2	15,770.8
Үндсэн хөрөнгө	71,389.0	66,546.5	-4,842.5
Нийт хөрөнгө	109,362.8	108,791.7	-571.1
Өр төлбөр	8,659.9	13,747.7	5,087.8
Урьдчилж орсон орлого	63,293.3	61,110.8	-2,182.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	37,409.6	33,933.2	-3,476.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	109,362.8	108,791.7	-571.1

Харилцах дансны үлдэгдэл 8,684.0 мянган төгрөг болж 1,934.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэлд 7,632.0 мянган төгрөг болж 13,433.7 мянган төгрөгөөр буурсан байна. Авлагын үлдэгдэлд сумын Соёлын төвөөс 4,772.1 мянган төгрөг, Ахмадын хорооноос 2,859.9 мянган төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын үлдэгдэл 25,929.2 мянган төгрөг болж 15,770.8 мянган төгрөгөөр өссөн нь сүлжээний насос нөөцөөр бэлтгэж худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,842.5 мянган төгрөгөөр элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 13,747.7 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 5,087.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн үлдэгдэлд нүүрсний өр 8,747.9 мянган төгрөг, татварын өглөг 4,999.7 мянган төгрөг байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 330,308.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,954.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,468.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой холбогдох горим сорилыг хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	225.8	1	225.8	100
Албан шаардлага	1	1,096.1	1	1,096.1	100
Зөвлөмж	1	74,732.3	1	74,732.3	50
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>76,054.2</b>	<b>7</b>	<b>76,054.2</b>	

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 0.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 5.7 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

##### 5.1 Төлбөрийн акт

###### 1. Илрүүлэлт

Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулалд 163.8 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 /үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захиран зарцуулах;/, 20.1.7/тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах/, 20.5 /Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна./, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.4 дэх /сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно/ заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

## **2. Илрүүлэлт**

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалинг илүү тайлагнаж 304.8 мянган төгрөгийн шимтгэлийг илүү шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 /үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;/, 20.1.7/тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах/, 20.5 /Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна./, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.4 дэх /сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно/ заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

## **5.2 Албан шаардлага**

### **1. Илрүүлэлт.**

Тооллогын комисс томилж, эд хөрөнгө нэг бүрийг үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1<sup>2</sup>, 72.4.2<sup>3</sup>, 72.4.4<sup>4</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>5</sup> дахь заалт болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

## **5.3 Зөвлөмж**

### **1. Шилэн данстай холбоотой**

#### **Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын

<sup>2</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>3</sup> тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

<sup>4</sup> комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

<sup>5</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

**2. Тээвэр шатахуунтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Тээвэр шатахууны 5.7 сая төгрөгийн зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил илэрлээ.

**Өгсөн зөвлөмж:**

Шатахууны зардалд тавих хяналтыг сайжруулж, шатахууны орлого, зарлагын гүйлгээг холбогдох анхан шатны баримтаар баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж байх.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон.	1	163.8	1	163.8	-	-	-	-	-	-	-	-
Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлж зардалд илэрхийлсэн.	1	304.7	1	304.7	-	-	-	-	-	-	-	-
Тооллогын комисс тооллого хийгээгүй зөрчил илэрлээ.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Тээвэр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>468.5</b>	<b>2</b>	<b>468.5</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зөрцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>